

“КОНКРЕТ АДМИКС” ХХК  
ЗАХИАЛАГЧ



“ЦАГААН УУЛЫН ОРГИЛ” ХХК  
ГҮЙЦЭТГЭГЧ

# 2023

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



УЛААНБААТАР ХОТ, СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ, 20-Р ХОРОО

УЛААНБААТАР ХОТ  
2022 ОН

## АГУУЛГА

Нэг. Төслийн товч танилцуулга

- 1.1. Төслийн тодорхойлолт
- 1.2. Орчны төлөв байдал, хяналт шинжилгээ

Хоёр. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл

- 2.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл
- 2.2. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Гурав. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

- 3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
- 3.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө
- 3.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
- 3.4. Осол эрслэцийн менежментийн төлөвлөгөө
- 3.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
- 3.6. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
- 3.7. Удирдлага, зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө
- 3.8. БОМТ-г олон нийтэд тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

Хавсралт

## ОРШИЛ

“Конкрет Адмикс” ХХК-ий Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй “Бетон зуурмагийн үйлдвэрт ашиглагдах химийн нэмэлт бодис импортлох, ашиглах, хадгалах, худалдах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Цагаан Уулын Оргил” ХХК боловсруулав.

Энэхүү БОМТ-нд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө, БОМТ-ний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр зэрэг нийт 31 багц ажлууд багтсан бөгөөд төслийн онцлог, байршлаас шалтгаалан нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө болон түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө хийгдэхгүй болно.

2023 оны БОМТ-нд ус, хөрс орчныг хамгаалах, ажилчдын эрүүл мэндэд чиглэсэн нийт 2.1 сая.төгрөг зарцуулахаар төлөвлөв.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн XI сарын 1-ний дотор тухайн жилийн БОМТ-ийн хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг XII сарын 31-ний дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төслийн товч тодорхойлолт

Төслийн нэр:	“Бетон зуурмагийн үйлдвэрт ашиглагдах химийн нэмэлт бодис импортлох, ашиглах, хадгалах, худалдах” төсөл
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:	“Конкрет адмикс” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011384111
Регистрийн дугаар:	5669456
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, 24а-11 тоот
Холбоо барих утас:	85747440
Төслийн зорилго:	Бетоны химийн нэмэлтийн нэр төрлийг олшруулах, зориулалтын бүтээгдэхүүнийг бетон зуурмаг болон бетон хийцийн үйлдвэрүүдэд нийлүүлэх, бетоны шинж чанарыг сайжруулагч нэмэлтүүдийг импортлох
Төслийн хүчин чадал:	30тн/хоног
Бүтээгдэхүүний нэр төрөл:	30 нэр төрлийн нэмэлт бодис
Сав, баглаа боодол:	1тн-ийн полипропилен сав (IBC танк)
Ажиллах хүч:	Нийт 9 ажилтан
Ажиллах хоног:	Жилд 168 хоног
Ус хангамж:	Төвийн шугамд холбогдсон, тоолуур суурилуулсан
Төслийн байршил, талбай хэмжээ:	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, 24-А, Тээвэрчдийн гудамж, “Хера Индастриал Парк”-ийн 380м <sup>2</sup> талбай бүхий агуулахын байрыг түрээсэлж үйл ажиллагаа явуулдаг.
Цахилгаан, дулаан хангамж:	Төвийн шугам сүлжээнд холбогдсон.
Агуулахын барилга:	Агуулахын байр нь “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага” MNS 6458:2014 стандарт хангасан байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй, цементэн шал, агаар сэлгэх салхивчтай, цонх хаалга нь төмөр хамгаалалттай, 24 цагийн харуул хамгаалалт, камертай.



Зураг 1. Паркийн үүд, харуул хамгаалалт



Зураг 2. Паркийн оффисын барилга



Зураг 3. Түрээсийн барилгын хэсэг



Зураг 4. Блюбус автобус компанийн гараж, ШТС





Зураг 5. Хера Индастриал Парк



Зураг 6. Агуулахын байршил

### Төслийн үндсэн үйл ажиллагаа:

"Хера Индастриал Парк" ХХК нь агуулахын зориулалттай объекийг ААНБ-уудад түрээслүүлдэг бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь 380м<sup>2</sup> талбай бүхий агуулахын байрыг түрээслэж үйл ажиллагаа явуулдаг. Түрээслэж буй хашааны зүүн талд Блюбус автобус компанийн гараж, шатахууны станц, хашааны хойд талд СХД-ийн авто оношлогооны төв, урд хэсэгт хайрганы үйлдвэр гэх мэт төрөл бүрийн агуулахын зориулалттай ААНБ-ууд үйл ажиллагаагаа явуулж байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь БНХАУ-ын Юцай (Yusai) компаниас химийн нэмэлт бодисуудыг импортлон худалдана. Импортоор оруулж ирж буй бараа бүтээгдэхүүнийг галт тэргээр, дотоодын тээвэрлэлтийг гэрээт автомашинаар тээвэрлэн, агуулахад автопогручкаар ачиж буулгадаг. Шингэн бодисуудыг 1тн ИВС танк, 225кг-ын төмөр сав, 50кг гялгар шуудай зэргийг битүүмжилсэн савлагаатай хүлээн авна.

Агуулахад 18 нэр төрлийн 10240тн бетон зуурмагийн химийн нэмэлт бодисыг хадгалан худалдах ба эдгээр бодисуудын 100% шингэн бодис байна .





Зураг 7. Түүхий эд



Зураг 8. Дулаан хангамж, галын булан, байгалийн гэрэлтүүлэг



Зураг 9. Аянга, цахилгааны газардуулга



Зураг 10. Ажиглалтын камер



Зураг 11. Хажуугийн B2 агуулах




Зураг 12. Түрээсэлж буй агуулахын байрны гадна ба дотор талын зохион байгуулалт

## 1.2. Орчны шинжилгээ

### а. Улаанбаатар хотын агаарын чанар

Төслийн байршлууд нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хамтарсан 2020 оны А/604-А/1112 дугаар тушаал/захирамжийн дагуу “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс”-ийн дагуу 1, 2, 3 дугаар бүсүүдэд хамаарч байна.



Зураг 13. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсчлэл  
(Эх сурвалж: [www.breathemongolia.org](http://www.breathemongolia.org))

Нийслэлийн агаарын чанарыг [www.agaar.mn](http://www.agaar.mn) сайтын агаарын чанарын суурин харуулын мэдээгээр тодорхойлов. Доорх хүснэгтээр хамгийн сүүлийн мэдээ болох 2022 оны 12 дугаар сарын 12-аас 12 дугаар сарын 18-ны өдрүүдийн агаарын чанарын мэдээг харуулав.


Хүснэгт 1. УБ хотын 2022.12.12-12.18-ий агаарын чанарын индексийн мэдээ

Огноо	Гэр хороолол									
	1-р хор-лол	100 айл	Толгойт	Нисэх	Зурагт	Баян-хошуу	Хайлааст	Шархад	Налайх	5-н буудал
12.12	SO <sub>2</sub> , PM2.5	SO <sub>2</sub>		SO <sub>2</sub>			PM2.5	SO <sub>2</sub>	SO <sub>2</sub>	SO <sub>2</sub> , PM2.5, PM10
12.13				SO <sub>2</sub> , PM2.5					SO <sub>2</sub>	SO <sub>2</sub>
12.14	SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , PM2.5, PM10	SO <sub>2</sub> , PM10				SO <sub>2</sub> , PM2.5, PM10	SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , PM10	SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , PM2.5	SO <sub>2</sub> , PM2.5,	
12.15						PM2.5	PM2.5	SO <sub>2</sub> , PM10	SO <sub>2</sub> , PM2.5	SO <sub>2</sub> , PM2.5, PM10
12.16	SO <sub>2</sub>		SO <sub>2</sub>	SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , PM2.5, PM10	SO <sub>2</sub> , PM2.5, PM10	PM2.5, PM10		SO <sub>2</sub>		PM2.5
12.17	SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , PM2.5, PM10	SO <sub>2</sub>	SO <sub>2</sub> , PM2.5,		PM2.5		SO <sub>2</sub> , PM2.5	SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , PM10	SO <sub>2</sub> , NO <sub>2</sub>	SO <sub>2</sub> , PM2.5, PM10
12.18	PM2.5	SO <sub>2</sub> , PM10, NO <sub>2</sub>			SO <sub>2</sub> , PM2.5		PM2.5		PM2.5	



Огноо	13-р хороолол	Автозам орчим		Үйлдвэрийн бүс			Алслагд-мал бүс	Агаарын чанар	Индексийн тоон үзүүлэлт
		Баруун 4 зам	Амгалан	Цахилгаан станц	Мишээл экспо	Зайсан	Ургах наран		
12.12		NO <sub>2</sub>						Цэвэр	0-50
12.13								Хэвийн	51-100
12.14	NO <sub>2</sub>	SO <sub>2</sub> , NO <sub>2</sub>		SO <sub>2</sub>				Бага бохирдолтой	101-200
12.15	SO <sub>2</sub> , NO <sub>2</sub>	NO <sub>2</sub>	SO <sub>2</sub> , NO <sub>2</sub>				SO <sub>2</sub>	Бохирдолтой	201-300
12.16								Их бохирдолтой	301-400
12.17		NO <sub>2</sub>	SO <sub>2</sub> , NO <sub>2</sub>	NO <sub>2</sub> , PM10				Маш их бохирдолтой	401-500
12.18	SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , PM10, PM2.5	SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , PM10	SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , PM10, PM2.5	SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , PM10	SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , PM2.5	SO <sub>2</sub> , NO <sub>2</sub>			

7 хоногийн агаарын чанарын хяналт шинжилгээний дүнгээр Улаанбаатар хотын агаарын чанар Цахилгаан станц, Мишээл экспо, Зайсан, Ургах наран хороолол орчим “Цэвэр” болон хэвийн, 13-р хороолол, Амгалан, Налайх, 100 айл, Толгойт, Нисэх, Баруун 4-н зам, Зурагт, Шархад орчим “Бага бохирдолтой”, 1-р хороолол, Баянхошуу, Хайлааст, 5-н буудал орчим “Бохирдолтой” түвшинд хүрсэн байна.



Зураг 14. Агаар бохирдуулагч түгээмэл бодисуудын түвшин (Эх сурвалж: www.agaar.mn)

Агаарын чанар бага бохирдолтой түвшинд хүрэхэд хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илрэх ба зүрх судас, амьсгалын замын архаг өвчтэй, ялангуяа гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс нөлөөлөлд өртөх магадлал илүү өндөр байдаг байна.

Хүснэгт 2. УБ хотын 7 хоногийн цаг агаар, өнгөрсөн онтой харьцуулахад

Цаг агаарын үзүүлэлт	2021 он	2022 он
Дундаж температур, °C	-18.6 °C	-20.7 °C
Салхины дундаж хурд, м/с	0.4 м/с	1.8 м/с
Хур тунадасны хэмжээ, мм	0.0 мм	0.8 мм

7 хоногийн цаг агаарын зарим үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад агаарын температур -2.1°C-ээр их хүйтэн, салхины дундаж хурд 1.4 м/с-ээр их, 0.8мм хур тунадастай байжээ.



## Хүснэгт 3. УБ хотын агаарын чанарын харьцуулалт /2021-2022 он/

Бохирдуулах бодисын нэр	MNS 4585:2016	7 хоногийн дундаж агууламж, мкг/м <sup>3</sup>		24 цагийн агууламж, мкг/ м <sup>3</sup>		Стандартаас давсан тоо, %	
	Хүлцэх хэмжээ, мкг/м <sup>3</sup>	2021	2022	2021	2022	2021	2022
Хүхэрлэг хий (SO <sub>2</sub> )	50	137	75	532	279	89	62
Азотын давхар исэл (NO <sub>2</sub> )	50	69	50	155	113	75	38
PM10 Тоосонцор	100	150	76	361	304	70	23
PM2.5 Тоосонцор	50	102	50	237	184	77	38
Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)	10,000	2804	1711	12328	8448	2.3	0
Озон (O <sub>3</sub> )	100	11	32	45	77	0	0

Улаанбаатар хотын 2022.12.12-аас 2022.12.18 хүртэл долоо хоногийн агаарын чанарыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хүхэрлэг хий (SO<sub>2</sub>) 5.5, азотын давхар исэл 2.2, PM10 3, PM2.5 3.6 дахин их байна. Агаарын чанарын дундаж агууламжийн мэдээгээр бодисуудын хэмжээ өмнөх оныхоос хэлбэлзэлтэй MNS 4585:2016 стандартын хүлцэх хэмжээнээс хэтэрсэн байна.

**б. Усны чанар, шинжилгээ**

Байгаль орчны төлөв байдлын судалгааны ажлын хүрээнд 2022.07.23-ны өдөр хэрэгцээний уснаас дээж авч “Нарт шуун консалтинг” ХХК-ий итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв.



Зураг 15. Усны шинжилгээний дээж авч буй байдал

## Хүснэгт 4. Усны физик шинж чанар

№	Усны дээж	Физик чанар				
		Өнгө	Үнэр	Амт	Тунадас	Булингар
1	Шугамын ус	Үгүй	0	0	-	Үгүй

## Хүснэгт 5. Усны химийн шинжилгээний дүн

Анион	1дм <sup>3</sup> -д байгаа			Катион	1дм <sup>3</sup> -д байгаа		
	мг/л	мг-экв/л	мг-экв/%		мг/л	мг-экв/л	мг-экв/%
CO <sub>3</sub> <sup>2-</sup>	0.0	0.0	0.0	Na <sup>+</sup>	22.00	0.96	13.08
HCO <sub>3</sub> <sup>-</sup>	288.00	4.72	64.47	K <sup>+</sup>			
Cl <sup>-</sup>	37.00	1.04	14.26	Ca <sup>++</sup>	78.00	3.89	53.19
SO <sub>4</sub> <sup>2-</sup>	70.00	1.46	19.91	Mg <sup>+</sup>	30.00	2.47	33.73
NO <sub>3</sub> <sup>-</sup>	6.20	0.10	1.37	Дүн	130.0	7.32	100
Дүн	401.2	7.32	100				

Хүснэгт 6. Усны ерөнхий шинж чанар

Усны дээж	НСО <sub>3</sub> <sup>-</sup> -ийн хагасыг хассан анион, катионуудын нийлбэр, мг/л	Анион, катионуудын нийлбэр, мг/л	Ерөнхий хатуулаг, мг-экв/л	Хуурай үлдэгдэл, мг/л	pH	TDS, ppm	ЦДЧ ЕС, ds/m
Шугамын ус	387.2	531.2	6.36	272	7.06	321	0.698

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, II-р төрлийн цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, хатуу ус бөгөөд “Ундны усны стандарт” Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартын шаардлагыг хангаж байна.

### в. Хөрсөн бүрхэвч

Төсөл хэрэгжих СХД-ийн 20-р хорооны нутаг дэвсгэрээр тал газар, хөндий хотгорын хөрс тархсан бөгөөд уулын ердийн хар шороон ба ердийн хархүрэн хөрсний төрөл зонхилж байна.

**Хөрсний төлөв байдлын шинжилгээ:** Судалгааны ажлын хүрээнд тус агуулах орчмын талбайгаас хөрсний бохирдлын түвшинг тодорхойлох зорилгоор эрүүл байж болох болон бохирдолтой хөрсний дээжийг 2022.07.23-ны өдөр авч Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхай, газрын тосны төв лабораторид шинжлүүлсэн.



Хүснэгт 7. Хөрсний дээж авсан тэмдэглэл

Сорьц авсан гүн	Өнгөн үе
Хөрсний өнгө	-
Сорьц авсан цэг	Агуулахын байрны гадна талбайгаас
Сорьц авсан цэгийн солбицол	47° 53' 59.6" N 106° 46' 45.3" E

Хүснэгт 16. Хөрсний дээж авсан цэг

Хүснэгт 8. Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн

Дээжний дугаар	Хөрс бохирдуулаг зарим бодисууд, мг/кг					
	Хром Cr	Хартугалга Pb	Кадми Cd	Цайр Zn	Зэс Cu	Никель Ni
№1	38.8	36.3	0.0	67.3	25.4	33.9
Элсэрхэг хөрс	60	50	1	100	60	60
<b>Шавранцар хөрс</b>	<b>100</b>	<b>70</b>	<b>1.5</b>	<b>150</b>	<b>80</b>	<b>100</b>
Шаварлаг хөрс	150	100	3	300	100	150

Шинжилгээний дүнг “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS5850:2019-тай харьцуулахад стандарт хэмжээнээс даваагүй байна.

## ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ БОЛОН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

### 2.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Хүснэгт 9. Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Хүний эрүүл мэндэд	Байгаль орчинд
Гол сөрөг нөлөөлөл	
<p>- Төслийн хэвийн үйл ажиллагааны явцад шууд сөрөг нөлөө үзүүлэхгүй.</p>	<p><b>Үйл ажиллагаанаас:</b>            - Тээвэрлэлт, хадгалалтын үед түүхий эдийн модон болон цаасан хайрцаг, гялгар уут зэрэг сав, баглаа боодлын хог хаягдал үүснэ.            - Ажилчдаас ахуйн хатуу хог үүснэ.</p> <p><b>Бодис, бүтээгдэхүүний хоруу чанараас:</b>            - Төслийн хэвийн үйл ажиллагааны явцад шууд сөрөг нөлөө үзүүлэхгүй.</p>
Болзошгүй сөрөг нөлөөлөл	
<p><b>Үйл ажиллагаанаас:</b>            - Ажиллагсад химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны дүрэм, журмын талаар мэдлэггүй, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлгүй ажиллах үед бодис асгарах, алдагдах тохиолдолд амьсгал, арьс салст, нүдэнд хүрэлцэх цочроох, хордлого зэрэг эрсдэл үүсч болзошгүй.            - Тоног төхөөрөмж, техник хэрэгслийн гэмтлээс ажиллагсад бэртэж гэмтэж болзошгүй.            - Ажиллагсдын дотоод журмын зөрчил, ажлын хариуцлага алдах зэргээс осол, эрсдэл үүсч болзошгүй.            - Байгалийн гамшигт үзэгдлийн улмаас хүний эрүүл мэнд, амь нас эрсдэж болзошгүй.</p> <p><b>Бодис, бүтээгдэхүүний хоруу чанараас:</b>            - Сав баглаа, тоног төхөөрөмжийн гэмтлийн улмаас бодис их хэмжээгээр асгарч агаарт тархах, хамар хоолой, уушги, амьсгалын замыг цоцроож болзошгүй.            - Арьс, нүдэнд хүрсэн тохиолдолд загатнуулж болзошгүй.            - Харшил үүсгэж болзошгүй.</p>	<p><b>Үйл ажиллагаанаас:</b>            -Бодис, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, тээвэрлэлт, хадгалалтын үеийн аюулгүй ажиллагаа алдагдах, осол эрсдлийн улмаас химийн бодис асгарах, алдагдах замаар агаарын болон хөрсний хими, физик шинж чанарыг өөрчлөх, бохирдуулах, байгаль орчинд тархах.            - Тээвэрлэлт хийж буй машины тос, тосолгооны материал асгарах, алдагдах зэргээр агуулахын хашааны хөрсийг бохирдуулж болзошгүй.</p> <p><b>Бодис, бүтээгдэхүүний хоруу чанараас:</b>            - Бодис, бүтээгдэхүүний сав, баглааны бүрэн бүтэн байдал алдагдсан, тоног төхөөрөмжийн эвдрэлийн улмаас бодис асгарах, тоос, дэгдэмхий нэгдэл агаарт тархах зэргээр агаар орчин, хөрсний бохирдол үүсгэж болзошгүй. Эрсдэл үүссэн тохиолдолд үйлдвэрийн байрны шал, гаднах ойр орчим нь бетонон хийцтэй учраас тархах орчин хязгаарлагдмал, хөрсөнд шууд алдагдах аюул бага.            - Химийн нэгдлүүд хөрсөнд их концентрацитай орвол хөрсний өнгөн давхарга бохирдох, хөрсний өөрийгөө цэвэршүүлэх чадвар алдагдаж, хүн амьтан, ургамалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.</p>



## 2.2 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Сөрөг нөлөөллийн эх үүсвэр	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Бууруулах, арилгах арга хэмжээ
Ажилчдын ахуйн болон бетоны нэмэлт бодисын баглаа боодлын хаягдал	Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, эмх цэгцтэй хураах буюу зориулалтын саванд хуримтлуулах, хадгалах	- Баглаа боодлын хог хаягдлуудыг цуглуулж дахин ашиглах, хоёрдогч түүхий эд авах цэгт тушаах, зарж борлуулах, - Дахин ашиглагдахгүй хаягдлыг ахуйн хог хаягдлын хамт Хера Индастриал Паркийн нэгдсэн хогийн цэгт хуримтлуулах, тусгай зөвшөөрөлтэй компаниар тээвэрлүүлэх.
Бодис, бүтээгдэхүүний хоруу чанар	- Бетоны нэмэлт бодисуудыг хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгалах, харьцаж ажиллах, тээвэрлэх - Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэлээр бүрэн хангах	- Түүхий эд, бэлэн бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн хурааж хадгалах, - Химийн бодисын анхааруулах тэмдэг, дохио үгээр тэмдэглэгээжүүлэх, - Эрсдэл тохиолдсон үед эмнэлгийн яаралтай тусламж авах, - Асгарсан бодисыг яаралтай цуглуулан авч саармагжуулах, устгах.
Ажилчдын буруутай үйл ажиллагаа	Аливаа осол, эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх үүднээс бодистой ажиллах, асгарч алдагдсан үед авах арга хэмжээний талаар мэргэшүүлэх сургалтыг ажилчдын дунд зохион байгуулж тэднийг чадавхижуулах	- Аюулгүй ажиллагааны дотоод журам боловсруулж мөрдөх, - Ажилчдад аюулгүй ажиллагааны заавар зөвлөгөөг сайтар өгч биелэлтэнд хяналт тавьж ажиллах - Бараа бүтээгдэхүүний өрөлтийг зөв, цэгцтэй хийх
Бүрэн бус техник хэрэгсэл	Дотоодын тээвэрлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгадаг байх, үзлэг оношилгоонд орсон тээврийн хэрэгслээр тээвэрлэлтийг хийлгэх,
Мэргэжлээс шалтгаалах өвчлөл	Ажилчдыг эмнэлгийн нарийн мэргэжлийн үзлэгт жил бүр хамруулж байх	Агуулахад анхны тусламжийн эмийн сан байршуулах
Цахилгаан, эрчим хүчний хэт их хэрэглээ	Хэрэглээгүй үед цахилгаан тоног төхөөрөмжийг унтрааж байх	Эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл сонгож ашиглах

Хүснэгт 11. Болзошгүй байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Байгалийн үзэгдэл	Гарч болзошгүй гамшиг, осол	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ
Аянга цахилгаан	Улаанбаатар хотод аянга цахилгаантай өдрийн тоо жилд дунджаар 21 өдөр байдаг. Аянгатай бороо жилд дунджаар 28 цаг үргэлжлэх бөгөөд хамгийн удаан үргэлжлэх сар нь 7 дугаар сар. Иймд эд хөрөнгө, эрүүл мэнд, амь насанд эрсдэл учруулах магадлалтай.	Суурьлуулсан аянга цахилгааны газардуулга, зайлуулагчийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавих
Бороо, үер усны аюул	Дулааны улиралд орсон их хэмжээний усархаг бороо, хаврын шар усны үерийн үлмаас үйлдвэрийн хашаа, агуулах, хогийн цэг зэрэг газрууд, химийн бодис усанд автах зэрэг осол аваар гарч болзошгүй.	Үерийн далан, шуудуу татах
Гал түймэр	Үйлдвэрийн цахилгааны шугаманд богино холболт үүсэх, ил гал гаргах, тамхи татах зэргээс шалтгаалан гал түймрийн аюул үүсч болзошгүй.	Гал унтраах багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих, үйлдвэрийн дотоод журмыг чанд сахих
Газар хөдлөлт	Улаанбаатар хот орчим нь газар хөдлөлтийн 7-8 баллын бүсэд хамаардаг тул агуулахад хураасан бүтээгдэхүүн нурах, өндөр даралттай халуун хий, усны шугам задарч үерт автах зэрэг эрсдлүүд гарах магадлалтай	Онцгой байдлын ерөнхий газартай гэрээ байгуулж сургалт зохион байгуулах, гамшгийн үеийн менежмент боловсруулж, мөрдөх



## ГУРАВ. 2023 ОНЫ БУЮУ ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Зорилго:** Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

### Гол зорилтууд:

"Конкрет Адмикс" ХХК-ийн төслийн 2023 оны БОМТ-г БОАЖСайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын дагуу боловсруулсан бөгөөд төслийн үйл ажиллагааны онцлог, байршил зэргээс шалтгаалан БОМТ-нд багтах нөхөн сэргээлтийн төлөвлөгөө; дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө; нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ; түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

БОМТ-нд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ, дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ, осол эрсдэл, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, БОМТ-ний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт 31 багц ажил багтсан бөгөөд төслийн 2023 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт 2.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөв.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний дотор тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу тайлагнах, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г жил бүрийн 12 дугаар сарын 31-ний дотор холбогдох байгууллагуудад хүргүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 12. 2023 оны БОМТ-ний зардлын товчоо, сая.төг

№	Менежментийн төлөвлөгөө	Хийгдэх ажлын тоо, багц	2023 он
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	2	-
2	Дүйцүүлэн хамгааллын менежментийн төлөвлөгөө	2	2.0
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3	-
4	Химийн бодис болон осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	13	Үйл ажиллагааны зардлаар
5	Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	6	
6	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	3	Дотоод зардлаар
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2	0.06
	Нийт зардал	31	2.06



## Хүснэгт 13. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил	Гарах үр дүн	Хамрах хүрээ	Хэрэгжих хугацаа, давтамж, зардал, мян.төг	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Агуулахын эзэмшил талбай дотор ил задгай хог хаягдал үүсгэхгүй байх	Хөрсийг бохирдохоос урьдчилан сэргийлнэ.	Агуулахын хүрээнд	Дотоод зардлаар	Эрүүл ахуйн тухай хуулийн 4.4.3, Хог хаягдлын тухай хуулийн 9.2.2, 9.4.8
Авто зогсоол болон бусад шороон зам талбайг услах	Орчны тоосжилт буурна		-	Агаар орчны чанарын үзүүлэлт, ерөнхий шаардлага MNS 4585-98 Ажлын бүсийн агаар. Эрүүл ахуйн шаардлага MNS 0012-013:91
Нийт дүн			-	

## Хүснэгт 14. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ, хэмжих нэгж	Нэгжийн үнэ, төг	Нийт үнэ, мян.төг	Хэрэг жүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн бичиг баримт
"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд эрх бүхий байгуулагаас гаргасан шийдвэрийн дагуу зохион байгуулагдах ажилд идэвх санаачлагатай оролцох	Заасан төслийн талбайд мод тарьж ургуулах		1500ш тарьц	2000.0		Төслийн хугацаанд	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
	Усалгаа, арчилгаа хийж занших						
Нийт дүн					2000.0		

## Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжих хугацаа, давтамж, зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх, тогтмол цэвэрлэгээ хийх	Агуулах ажилчдад	Гэрээнд заасны дагуу	"Хог хаягдлын тухай хууль"-ийн 9.2.8, 9.2.9, 12-р зүйл
Энгийн хог хаягдал зайлуулах төлбөр			"Эрүүл ахуйн тухай хууль"-ийн 4.4.3, "Хог хаягдлын тухай хууль"-ийн 9.2.8, 9.2.9, 12-р зүйл
Аюултай хог хаягдал зайлуулдаг тусгай зөвшөөрөлтэй компанид нийлүүлэх			
Нийт дүн		-	-

## Хүснэгт 16. Химийн бодис болон осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний төсөв

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний, цар хүрээ	Нэгжийн зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн барим бичиг
<b>Тээвэрлэх</b>				
Тээвэрлэлт хийж буй жолооч нарыг сургалтанд хамруулж, химийн бодисын хор аюул, аюулгүй ажиллагааны талаар мэдлэг олгож байх	Агуулахын хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар	Улиралд бүр	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 12-р зүйл
Химийн бодисыг тээвэрлэхдээ сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг хянадаг байх, асгарч алдагдсан үед хураан авах, саармагжуулах, хоргүйжүүлэх материал, гал унтраах багаж хэрэгслээр тээврийн хэрэгслийг тоноглох			Тогтмол	
<b>Хадгалах</b>				
Химийн бодис хадгалах агуулахыг стандартын дагуу тохижуулах, агуулахын орчим ил гал гаргах, тамхи татахгүй байх	Агуулахын хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар	Төслийн хугацаанд	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 13-р зүйл
Химийн бодис асгарч алдагдах, ажиллагсад хордох, бэртэх гэмтэх, галын аюулын үед бодисыг хураан авах сав, хүрз, хоргүйжүүлэх саармагжуулах бодис урвалж, яаралтай тусламжийн эмийн сан, гал унтраах багаж хэрэгсэл бэлэн байлгах				
Болзошгүй эрсдэл тохиолдсон үед эрсдлийг бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрсдлийн сан үүсгэх, байнгын бэлэн байдалд байлгах				
<b>Эрсдэл тохиолдсон үед авах арга хэмжээ</b>				
Гал гарсан тохиолдолд гал унтраагуур, гал түймрийн голомтод ажиллагсдыг бүх биеийг хамгаалах хувцас, хэрэглэл, бээлий, хорт утааны багтай ажиллах нөхцөлөөр хангах	Агуулахын хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар	Шаардлагатай тохиолдолд	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 17-р зүйл
Химийн бодис асгарсан тохиолдолд химийн бодис хадгалах зориулалтын саванд цуглуулах, шингээгч материал ашиглах, асгарсан талбайг сайтар цэвэрлэх, агааржуулах				
Нүд, арьс салст, амьсгал болон залгисан тохиолдолд зааврын дагуу арга хэмжээ авах, эмнэлэгийн тусламж үзүүлэх.				
Ноцтой ослын үед аюулын бүс тогтоох, энэ талаар мэргэжлийн байгууллага (ОБЕГ, МХЕГ)-д нэн даруй мэдэгдэж орчны хяналт шинжилгээний талаар дүгнэлт гаргуулах, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулах				Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 17-р зүйл

Эрсдэл тохиолдсоны дараа авах арга хэмжээ, хяналт мониторинг				
Эрсдэлд өртсөн жолооч, ажиллагсад, ойр орчмын хүн амыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах, өвчлөлийг бүрэн эмчлэх	Агуулахын хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар	Шаардлагатай тохиолдолд	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 болон 15-р зүйл
Эрсдлийн улмаас бохирдолд өртсөн тухайн орчин болон агуулах орчим бодис тархсан эсэхэд хяналт, мониторинг хийх, тухайн орчныг цэвэрлэх, үүссэн хаягдлыг зохих журмын дагуу зайлуулж, устгах, дахин эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх				
Химийн бодисын хор аюулын зэрэг, болзошгүй эрсдэл, эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрсдэл тохиолдсон үед авах арга хэмжээ зааврын талаар ажиллагсдад тогтмол сургалт явуулах, анхааруулах, хүлээн авах чадварыг сайжруулах.				
Осол, эрсдэлд өртсөн эд хөрөнгө, тоног төхөөрөмжийн хохирлыг тооцох, хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс засвар, шинэчлэлийн ажлыг хийх, дахин эрсдэл үүсэхээс сэргийлэх				
Нийт дүн				

Хүснэгт 17. Компанийн удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Хугацаа	Урьдчилсан тооцсон төсөв, мян. төг	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
<b>1. Хуулийн хэрэгжилтийг хангуулах</b>				
БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан үйл ажиллагааг зохион байгуулах, дотоод журам тогтоож мөрдөх	Төслийн нийт хугацаанд	Дотоод зардал	Байгаль орчин хариуцсан менежер	"Байгаль орчныг хамгаалах тухай хууль"-ийн 31.7 заалт
Химийн хорт болон аюултай бодисыг импортлох, ашиглах тусгай зөвшөөрлийг байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагаас авч ажиллах				"Химийн хорт болон аюултай бодисын тухай" хуулийн 5, "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 15.6.3-р заалт
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд нь хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг байгаль орчны хяналтын байгууллагад хүргүүлж байх	Жил бүрийн 11-р сарын 1-ээс өмнө	,		"Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хууль"-ийн 14.1.2 заалт
Байгаль хамгаалахад дүүргийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Жил бүрийн 6-р сард	,	Байгаль орчин хариуцсан менежер	"Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам" БОНХ-ийн сайдын 2014 оны А-03 тоот тушаалын хавсралт



Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх	Жил бүр			“Хог хаягдлын тухай” хуулийн шинэчилсэн найруулга, 2017
Ажилчдыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтанд шинээр болон гүйцэтгэх ажлын үүрэг хариуцлага өөрчлөгдсөн тохиолдолд хамруулж чадавхижуулж байх	Жил бүр	Дотоод зардал	Байгаль орчин хариуцсан менежер	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн 27.3.4, 28.1.8-р заалт “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 13.6
Нийт дүн	-			

Хүснэгт 18. БОМТ-г эрх бүхий байгууллага, олон нийтэд тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

Оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Агуулга	Хугацаа	Санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Хорооны иргэд	Тайлагнах, хэлэлцүүлэх	Төслийн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажил	Жил бүрийн 10 сард	Байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг танилцуулах	Компанийн байранд
Шаардлагатай тохиолдолд сонирхогчид, байгаль орчны төрийн бус байгууллага			Шаардлагатай тохиолдолд		
Нийслэлийн байгаль орчны газар	БОМТ хэрэгжилтийг тайлагнах	Төслийн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах талаар хийгдсэн ажил, БОМТ-ний тайлан	Жил бүрийн 11 сарын 01-нээс өмнө	БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, дараа оны БОМТ-нд өгөх санал, зөвлөмж	Нийслэлийн байгаль орчны газарт
БОАЖЯ	БОМТ-ний тайлан, төлөвлөгөөг батлуулах	Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ авах, хяналт шинжилгээний дагуу хийсэн ажлыг биелэлтийг тайлагнах	Жил бүрийн 12-р сарын 30-наас өмнө	Цаашид хэрэгжүүлэх ажил болон хийгдэж буй ажилд зөвлөгөө өгөх, үнэлж дүгнэх	БОАЖЯ-нд

## Хүснэгт 19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ	Дээж авах байршил	Давтамж	Нийт үнэ мян.төг	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Хөрс	Хогийн цэг, авто зогсоол, агуулахын байрны ачилтын талбайгаас	Жилд 1 удаа	30*1	Хром, Cr	150мг/кг
				Хар тугалга, Pb	100мг/кг
				Кадмий, Cd	3мг/кг
				Никель, Ni	150мг/кг
				Цайр, Zn	300мг/кг
				Зэс, Cu	100мг/кг
				Төмөр, Fe	
Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019					
Ундны ус	Хэрэглээний ус	Жилд 1 удаа	30*1	рН	6.5-8.5
				Ерөнхий хатуулаг	7.0мг-экв/л
				Хлорид ион	350.0мг/л
				Сульфатын ион	500.0мг/л
				Кальцийн ион	100.0мг/л
				Магнийн ион	30.0мг/л
				Натри ион	200.0мг/л
"Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ" MNS 0900:2018					
Нийт дүн			60.000		

## ХАВСРАЛТ

1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
2. Агуулахын түрээсийн гэрээний хуулбар
3. Аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээний хуулбар
4. Газрын байршлын кадастрын зураг
5. "Нарт шүүн консалтинг" ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторийн хөрсний шинжилгээний дүнгийн хуулбар
6. "Нарт шүүн консалтинг" ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторийн усны шинжилгээний дүнгийн хуулбар
7. Байгаль орчны төлөв байдлыг судалгаа хийсэн мэргэжлийн байгууллагын гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017.12.12-ны өдрийн А/349-р тушаал "Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл"
- "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмж", 2019 он
- Байгаль орчны хуулийн эмхэтгэл, УБ хот, 2012 он
- Бусад холбогдолтой мэдээ материал


## ЦАХИМ ХУУДАС

[www.mne.mn](http://www.mne.mn)  
[www.estandart.mn](http://www.estandart.mn)  
[www.ub.gov.mn](http://www.ub.gov.mn)  
[www.ser.nl](http://www.ser.nl)

[www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)  
[www.nema.gov.mn](http://www.nema.gov.mn)  
[www.eic.mn](http://www.eic.mn)  
[www.limitvalue.ifa.dguv.de](http://www.limitvalue.ifa.dguv.de)



# “НАРТ ШУҮН КОНСАЛТИНГ” ХХК ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан  
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10  
Утас: (976)-99176123, 99231836

E-mail: [nartconsulting@gmail.com](mailto:nartconsulting@gmail.com)

№ 21/03-19-1

Захиалагч: “Цагаан Уулын Оргил” ХХК  
Дээж авсан цэг: “Конкрет адмикс” ХХК, СХД 20 хороо  
Сорьц авсан огноо: 2022 оны 07 сар 23 өдөр  
Уст цэгийн төрөл:  
Зориулалт:  
Харилцах утас:  
Аргын стандарт: MNS1097:1970

Катион	1 дм <sup>3</sup>			Анион	1 дм <sup>3</sup>		
	мг/л	мг-экв/л	мг-экв/%		мг/л	мг-экв/л	мг-экв/%
Na <sup>+</sup>				CO <sub>3</sub> <sup>-</sup>	0.0	0.0	0.0
K <sup>+</sup>	22.00	0.96	13.08	HCO <sub>3</sub> <sup>-</sup>	288.00	4.72	64.47
Ca <sup>++</sup>	78.00	3.89	53.19	Cl <sup>-</sup>	37.00	1.04	14.26
Mg <sup>++</sup>	30.00	2.47	33.73	SO <sub>4</sub> <sup>-</sup>	70.00	1.46	19.91
				NO <sub>3</sub> <sup>-</sup>	6.20	0.10	1.37
Дүн	130.0	7.32	100	Дүн	401.2	7.32	100

Анион катионуудын нийлбэр:

(Σ<sub>A+K</sub> 531.2 мг/л

HCO<sub>3</sub> ийн хагасыг хассан анион,  
катионуудын нийлбэр: 387.2 мг/л

**Физик үзүүлэлтүүд**

Өнгө: 0-өнгөгүй,

Үнэр: 0-үнэргүй

Булингар: Булингаргүй

Тунгалаг: Тунгалаг

Хуурай үлдэгдэл, мг/л: 272 ppm

Ерөнхий хатуулаг: 6.36 мг-экв/л  
*/хатуу ус/*

Урвалын орчин: pH- 7.06

Цахилгаан дамжуулах чадвар:

EC -0.698 ds/m

TDS: 321 ppm

$$M(0.53) = \frac{HCO_3 \ 64 \ [SO_4 \ 20Cl \ 14]}{Ca \ 53Mg \ 34 \ [Na \ 13]}$$

Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, II төрлийн цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, хатуу ус.

Жич: усны сорцыг шинжлүүлсэн байгууллага хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.

ЗАДЛАН ШИНЖЛЭГЧ:

ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ӨРХЛӨГЧ:

Га.СОЛОНГО


Г.СОЛОНГО Ph.D







# “НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан  
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10  
Утас: (976)-99176123, 99231836

E-mail: [nartconsulting@gmail.com](mailto:nartconsulting@gmail.com)

№ 21/03-16/1

Захиалагч: “Цагаан уулын оргил” ХХК

Дээж авсан цэг: “Конкрет адмикс” ХХК, СХД 20-р хороо

Сорьц авсан огноо: 2022 оны 07 сар 23 өдөр

Шинжилгээ хийсэн огноо: 07 сарын 25

Харилцах утас:



## 1. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
		мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Дээж 2	0-10	38.8	36.3	0.0	67.3	25.4	33.9
<b>Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019</b>							
Элсэрхэг хөрс		60	50	1	100	60	60
<b>Шавранцар хөрс</b>		<b>100</b>	<b>70</b>	<b>1.5</b>	<b>150</b>	<b>80</b>	<b>100</b>
Шаварлаг хөрс		150	100	3	300	100	150

*\*Харгалзах түвшин \* Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарна.*

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД :

(Хүнд металлуудыг -хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр  
MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН:  Х.УУГАНЦЭЦЭГ, Га.СОЛОНГО  
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ:  Г.СОЛОНГО Ph.D



Байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Цагаан уулын оргил” ХХК

Хаяг: Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн Өргөн Чөлөө,  
“Бизнес плаза” 501 тоот

Утас: 7013 1114, 99184930

Цахим хаяг: [tsagaanuuiliinorgil@gmail.com](mailto:tsagaanuuiliinorgil@gmail.com)

Фэйсбүүк: “Цагаан уулын оргил” ХХК Байгаль орчны зөвлөх үйлчилгээ